



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/183

Мандалговь

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Мандалын говийн хурд” ХХК-ны хүнсний дэлгүүрийн тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 08-ний өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

2. Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан тавигдах шаардлагыг биелүүлж, үйл ажиллагаа явуулж буй объектынхоо эргэн тойрны 50 метр газрын цэвэрлэгээ болон хотын тохижилт, соёлжилтод онцгой анхааран, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг иргэн (Б.Оюунбат)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Саранзаяа), Цагдаагийн хэсгийн байцаагч (Б.Билгүүн), (А.Өлзийбуян) үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ